

АГУУЛГА

ОРШИЛ	2
БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
1.2. Төслийн үйл ажиллагааны хураангуй.....	4
1.2.1. Уурхайн хүний нөөц, уурхайн кемп	8
1.2.2. Дэд бүтэц.....	8
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	10
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ... 15	
БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	19
БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
5.1. Байгаль хамгаалах төлөвлөгөө.....	22
5.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	22
5.1.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	24
5.1.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	24
5.1.4. Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны төлөвлөгөө	24
5.1.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	24
5.1.6. Түүх, соёлын өвийг хамгаалах, арга хэмжээний төлөвлөгөө.....	25
5.1.7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	25
5.1.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	26
5.1.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	27
5.1.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	29
5.1.11. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь 30	
5.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал.....	30
ДҮГНЭЛТ	31
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	32

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт № 1 Төслийн ерөнхий мэдээлэл	3
Хүснэгт № 2 MV-000296 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгийн солбилцол	3
Хүснэгт № 3 MV-020868 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгийн солбилцол	4
Хүснэгт № 4 Эвдэрсэн талбайн хэмжээ /MV-000296, MV-020868/.....	5
Хүснэгт № 5 Ил уурхайн технологийн агуулга, бүрдэл	6
Хүснэгт № 6 Тээвэрлэлтийн дундаж зай.....	7
Хүснэгт № 7 Угаан баяжуулах хэсгийн хүчин чадлын төлөвлөлт	8
Хүснэгт № 8 Төслийн нийт ажилчдын тоо	8
Хүснэгт № 9 Барилга байгууламжийн мэдээлэл	9
Хүснэгт № 10 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	22
Хүснэгт № 11 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал.....	24
Хүснэгт № 12 Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд тарих модны төлөвлөгөөний зардал.....	24
Хүснэгт № 13 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	25
Хүснэгт № 14 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	26
Хүснэгт № 15 ОХШХ-ийн мониторингийн цэгүүдийн координат	27
Хүснэгт № 16 Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө	29
Хүснэгт № 17 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	29
Хүснэгт № 18 БОМТ-ний хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	30
Хүснэгт № 19 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	30

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг № 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байршлын зураг	4
Зураг № 2 Төслийн талбайн одоогийн байдал	5
Зураг № 3 Үйлдвэрлэлийн технологийн бүдүүвч	7
Зураг № 4 ОХШХ-ийн мониторингийн цэгүүд.....	28

ОРШИЛ

“Ирмүүнбосго” ХХК-ийн “Хайлаастын алтны үүсмэл болон шороон ордуудыг ил аргаар ашиглах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 117,575.0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт № 1 Төслийн ерөнхий мэдээлэл


№	Ерөнхий мэдээлэл	
1	Төслийн нэр	Хайлаастын алтны үүсмэл болон шороон ордуудыг ил аргаар ашиглах
2	Ашигт малтмалын төрөл	Алт
3	Засаг захиргааны нэгж	Төв аймаг, Заамар сум, Хайлааст баг
4	Төслийн хугацаа	Төсөл 4 жил хэрэгжинэ
5	Төсөл хэрэгжүүлэгч	Ирмүүн босго ХХК
6	Улсын бүртгэлийн дугаар	9011244141
7	Регистрийн дугаар	5396786
8	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион оргил /17010/, чингисийн өргөн чөлөө, 6е, 28 тоот
9	Тусгай зөвшөөрөл	<ul style="list-style-type: none"> – Орд ашиглах тусгай зөвшөөрөл MV-000296: Ашигт Малтмал Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газраас “Алтандорнод Монгол” ХХК-д 228.21 гектар талбай бүхий уурхайн эдэлбэр газарт ашигт малтмал ашиглах эрхийг олгож MV-000296 дугаар бүхий тусгай зөвшөөрлийг 2007 оны 02 дугаар сарын 20-ны өдөр анх олгосон бөгөөд 2017 оны 10 дугаар сарын 05-ны өдөр “Турван тамга” ХХК, 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдөр “Цариг шонхор” ХХК шилжүүлэн авсан ба улмаар 2020 оны 07 дугаар сарын 23-ны өдөр “Ирмүүнбосго” ХХК-д шилжүүлсэн байна. – Орд ашиглах тусгай зөвшөөрөл MV-020868: Анх Ашигт Малтмал Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газраас “Алтандорнод Монгол” ХХК-д 1995.10.14-нд олгосон MV-000296 тоот тусгай зөвшөөрлийг хэсэгчлэн шилжүүлж шинэ тусгай зөвшөөрөл олгох 2017.07.24-ний 419 тоот шийдвэр гарсан байна. 2020.03.18-ны 89 тоот шийдвэрээр 81.54 гектар талбай бүхий уурхайн эдэлбэр газарт ашигт малтмал ашиглах эрхийг “Юбиксолюшн” ХХК-д шилжүүлж 2023.05.24-ны 162 тоот шийдвэрээр “Ирмүүн босго” ХХК-д шилжүүлсэн байна.

Хүснэгт № 2 MV-000296 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгийн солбилцол

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	104° 30' 52.63"	48° 20' 47.94"	19	104° 32' 31.93"	48° 19' 55.73"
2	104° 30' 01.64"	48° 20' 47.72"	20	104° 32' 18.11"	48° 19' 55.68"
3	104° 30' 01.85"	48° 20' 25.88"	21	104° 32' 18.03"	48° 20' 02.16"
4	104° 30' 52.84"	48° 20' 26.10"	22	104° 32' 05.90"	48° 20' 02.12"
5	104° 30' 52.91"	48° 20' 19.63"	23	104° 32' 05.81"	48° 20' 11.82"
6	104° 31' 02.61"	48° 20' 19.67"	24	104° 31' 48.83"	48° 20' 11.76"
7	104° 31' 02.70"	48° 20' 11.57"	25	104° 31' 48.76"	48° 20' 18.24"
8	104° 31' 24.55"	48° 20' 11.65"	26	104° 31' 36.62"	48° 20' 18.19"
9	104° 31' 24.60"	48° 20' 05.18"	27	104° 31' 36.58"	48° 20' 23.03"
10	104° 31' 22.17"	48° 20' 05.18"	28	104° 31' 25.66"	48° 20' 22.99"
11	104° 31' 22.27"	48° 19' 55.46"	29	104° 31' 25.60"	48° 20' 27.87"
12	104° 31' 41.69"	48° 19' 55.54"	30	104° 31' 24.39"	48° 20' 27.85"
13	104° 31' 41.73"	48° 19' 50.68"	31	104° 31' 24.29"	48° 20' 39.18"
14	104° 31' 55.09"	48° 19' 50.75"	32	104° 31' 09.71"	48° 20' 39.11"
15	104° 31' 55.14"	48° 19' 44.26"	33	104° 31' 09.73"	48° 20' 37.49"
16	104° 32' 06.06"	48° 19' 44.32"	34	104° 30' 57.59"	48° 20' 37.45"
17	104° 32' 06.14"	48° 19' 36.31"	35	104° 30' 57.54"	48° 20' 43.93"
18	104° 32' 31.93"	48° 19' 36.33"	36	104° 30' 52.67"	48° 20' 43.91"

Хүснэгт № 3 MV-020868 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгийн солбилцол

Д/д	Уртраг	Өргөрөг	Д/д	Уртраг	Өргөрөг
1	104° 32' 54.51"	48° 19' 55.83"	10	104° 33' 33.63"	48° 19' 23.61"
2	104° 32' 31.93"	48° 19' 55.73"	11	104° 33' 33.57"	48° 19' 30.08"
3	104° 32' 31.93"	48° 19' 36.33"	12	104° 33' 26.29"	48° 19' 30.05"
4	104° 32' 35.26"	48° 19' 36.33"	13	104° 33' 26.22"	48° 19' 38.15"
5	104° 32' 35.30"	48° 19' 33.10"	14	104° 33' 16.51"	48° 19' 38.11"
6	104° 32' 42.58"	48° 19' 33.13"	15	104° 33' 16.46"	48° 19' 43.77"
7	104° 32' 42.60"	48° 19' 29.88"	16	104° 33' 06.75"	48° 19' 43.74"
8	104° 32' 49.88"	48° 19' 29.91"	17	104° 33' 06.71"	48° 19' 50.21"
9	104° 32' 49.94"	48° 19' 23.44"	18	104° 32' 54.57"	48° 19' 50.17"




Зураг № 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байршлын зураг

1.2. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

Уурхайн одоогийн байдал

Ашиглалтын MV-000296, MV-020868 тоот тусгай зөвшөөрлүүдийн талбай нь хоорондоо залгаа оршдог. Тусгай зөвшөөрлүүдийн талбай тус бүр дээр өмнө ашиглаж байсан компаниуд тодорхой хэмжээгээр үйл ажиллагаа явуулж байсан.



Зураг № 2 Төслийн талбайн одоогийн байдал

Төсөл хэрэгжих MV-000296 тоот тусгай зөвшөөрлийн талбайд одоогийн байдлаар 89.66 га талбай эвдэрсэн байна. MV-020868 тоот тусгай зөвшөөрлийн талбайд одоогийн байдлаар 35.91 га талбай эвдэрсэн байна. Доорх хүснэгтэд эвдэрсэн талбайн хэмжээг тусгай зөвшөөрлийн талбай тус бүрээр харуулав.

Хүснэгт № 4 Эвдэрсэн талбайн хэмжээ /MV-000296, MV-020868/

№	Эвдрэл үүсэх талбай	Х.нэгж	Эвдэрсэн газар	
			MV-000296	MV-020868
1	Ил уурхайгаар эвдэгдэх	га	77.69	34.83
2	Барилга байгууламж талбай, засварын хэсэг	га	8.03	-
3	Уурхайн шороон зам	га	3.95	1.08
	Нийт		89.66	35.91

Тусгай зөвшөөрлүүдийн талбай дахь үлдэгдэл геологийн нөөц

Нийт MV-000296, MV-020868 тоот тусгай зөвшөөрлүүдийн хэмжээнд бодитой (B) зэрэглэлээр 175.47 мян.м³ буюу химийн цэврээр 50.21 кг, боломжтой (C) зэрэглэлээр 91.96 мян.м³ буюу химийн цэврээр 18.55 кг, нийт бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр 267.43 мян.м³ буюу химийн цэврээр 68.76 кг алтны нөөцтэй байна.

Ил уурхайн ашиглалтын нөөц

Ил уурхайн хүрээнд бодитой (B) зэрэглэлээр 166.91 мян.м³ элс буюу шлихээр 51.61 кг (химийн цэврээр 46.14 кг) алт, боломжтой (C) зэрэглэлээр 87.92 мян.м³ элс буюу шлихээр 19.34 кг (химийн цэврээр 17.79 кг) алт, нийт бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр 254.83

мян.м³ элс буюу шлихээр 70.95 кг (химийн цэврээр 63.93 кг) алт ил уурхайн хүрээгээр олборлогдоно. Нийт ил уурхайн хүрээнд 955.62 мян.м³ хөрс орж байна.

Үйлдвэрлэлийн нөөц

Ордын нийт магадласан В' үйлдвэрлэлийн нөөц нь **290.01** мян.м³ элс буюу химийн цэврээр **63.29** кг алт орж байна. /Шлихээр 70.24 кг/. Нийт 1,621.76 мян.м³ хөрс орж байна. /Сорьц-938, Сорьц-866, Сорьц-849, Сорьц-898/

Уулын ажлын төлөвлөлт

Уурхайн 1 дэх жилийн уулын ажлын төлөвлөлт: 1 дэх жилд ил уурхайн төлөвлөлтийг MV-020868 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Дэнж-2 хэсгээс олборлож эхлэх ба үргэлжүүлэн MV-000296 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн үүсмэл ба тодорхой нөхцөлд үр ашигтай нөөцийн блокуудаас олборлохоор төлөвлөсөн байна.

Ашиглалтын 1 дэх жилд бодитой (В) зэрэглэлээр 85.15 мян.м³ элс буюу химийн цэврээр 26.27 кг алт, боломжтой (С) зэрэглэлээр 40.54 мян.м³ элс буюу химийн цэврээр 6.79 кг алт, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 125.69 мян.м³ элс буюу химийн цэврээр 33.06 кг алт олборлохоор төлөвлөсөн.

Мөн 1 дэх жилд өмнөх онуудад бий болсон үүсмэл нууруудыг ашиглах ба эфель галиар нөхөн дүүргэлт хийхээр тооцов. Олборлолтын үед үүссэн хоосон орон зайд дотоод овоолго хийхээр төлөвлөлөө.

Уурхайн 2 дахь жилийн уулын ажлын төлөвлөлт: 2 дахь жилд ил уурхайн 1 дэх жилийн төлөвлөлтийг үргэлжүүлэн MV-000296 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн үүсмэл ба тодорхой нөхцөлд үр ашигтай нөөцийн блокуудыг олборлохоор төлөвлөсөн байна.

Ашиглалтын 2 дахь жилд бодитой (В) зэрэглэлээр 102.04 мян.м³ элс буюу химийн цэврээр 19.41 кг алт, боломжтой (С) зэрэглэлээр 62.28 мян.м³ элс буюу химийн цэврээр 10.82 кг алт, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 164.32 мян.м³ элс буюу химийн цэврээр 30.24 кг алт олборлохоор төлөвлөсөн байна.

Ил уурхайн процесс

Ашиглалтын технологи: Ордын талбай нь хэвтээ уналтай 3-7⁰ налуутай, нөөцийн блокийн өргөн жигд үргэлжилдэг тул ашиглалт явуулсан талбайд дотоод овоолго хийж ашиглах боломжтой ордын ашиглалтад ил аргаар тээвэртэй дотоод овоолготой ашиглалтын системийг ашиглаж байна.

Хүснэгт № 5 Ил уурхайн технологийн агуулга, бүрдэл

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Ил аргаар тээвэртэй, дотоод овоолготой ашиглалтын технологи	Хөрс хуулалт	1.1 Шимт хөрсийг хуулах 1.2 Шимт хөрсийг ачих 1.3 Шимт хөрсийг тээвэрлэх 1.4 Хөрсийг ухаж, ачих 1.5 Хөрсийг тээвэрлэх 1.6 Дотоод овоолгод хураах 1.7 Овоолгыг түрэх

	Элс олборлолт	1.8 Элс ухаж, ачих 1.9 Элс тээвэрлэх 1.10 Түр овоолгод хураах
--	---------------	---

Уурхайн дотоод тээвэр


Элс тээвэрлэж ирсэн автосамосвал нь уурхайн угаах төхөөрөмжөөс гарсан галийг тээвэрлэн буцах ба уурхайн ухагдсан хоосон орон зайг дүүргэлт хийхээр тооцсон байна.

Хүснэгт № 6 Тээвэрлэлтийн дундаж зай

Ашиглалтын жил	Тээвэрлэх дундаж зай, м		
	Шимт хөрс	Хөрс	Элс
1 дэх жил	180	647.12	788.66
2 дахь жил	220	727.12	769.07
Дундаж	200	687	779

Уурхайн угаан баяжуулах хэсэг

Ил уурхайн элс олборлолтын төлөвлөгөө болон захиалагчаас өгсөн техникийн даалгавар болон олборлолт явуулах блокууд хоорондоо зайтай зэргийг үндэслэн элс угаан баяжуулах хэсэг нь 2 хэсэгт байрлуулахаар төлөвлөв. Элс олборлолтын дараа үлдсэн орон зайд баяжуулах хэсгээс гарсан эфель, галийн хаягдлыг түрэх байдлаар нөхөн дүүргэхээр төлөвлөсөн.



Зураг № 3 Үйлдвэрлэлийн технологийн бүдүүвч

Төслийн хугацаанд жилийн 04 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 15-ны хооронд хоногт 2 ээлжээр, 12 цагаар ажиллахаар төлөвлөсөн. ТЭЗҮ-ийн хүрээнд ашиглагдах алтны шороон ордын нөөц тооцсон блокууд нь хоорондоо зайтай, элс тээвэрлэлтийн зай хол учраас угаан баяжуулах хэсэгт 2 ширхэг угаах төхөөрөмж ажиллана.

Хүснэгт № 7 Угаан баяжуулах хэсгийн хүчин чадлын төлөвлөлт

№	Үзүүлэлтүүд	1 дэх жил	2 дахь жил
1	Жилийн хуанлийн өдрийн тоо	183	183
2	Жилийн хуанлийн сар	7	7
3	Ээлжийн тоо	2	2
4	Хоногт ажиллах цаг	12	12
5	Өдөрт ажиллах нийт цаг	24	24
6	Цайны цаг	2	2
7	Ээлж хүлээлцэх хугацаа	2	2
8	Хоногт бүтээлтэй ажиллах хугацаа	20	20
9	Өдөрт ажиллах нийт цаг	6	6
10	Баяр ёслол	15	15
11	Бэлтгэл ажил	13	13
12	Цаг агаарын саатал	3	3
13	Жилд ажиллах бодит өдөр	146	146
14	Үйлдвэрийн цаг ашиглалт, %	90	90
15	Цагийн хүчин чадал, м ³ /цаг	52.61	68.78
16	Хоногийн хүчин чадал, м ³ /хоног	1,262.66	1,650.67
17	Жилд олборлох элс, м ³ /жил (сийрэгжсэнээр)	138,261.38	180,748.04

Бүтээгдэхүүн гаргалт

Ордоос нийт 0.242 гр/м³ агуулгатай, 290.01 мян.м³ элс олборлох бөгөөд үүнийг гравитацийн аргаар баяжуулж, 92.60 хувийн металл авалттайгаар төслийн нийт хугацаанд 65.04 кг шлихийн алт, химийн цэврээр 58.61 кг алт үйлдвэрлэн борлуулна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт

Уурхайн ашиглалтын хугацаанд нийт 290.01 мян.м³ элсийг олборлон 58.61 кг химийн цэвэр алтыг борлуулах бөгөөд нэг гр алтны үнийг 436,110.44 төгрөг байхаар тооцсон.

Уурхайн ашиглалтын хугацаанд нийт 25,560.88 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 17,007.33 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, хандив тусламжийн дараах байдлаар 7,573.08 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллана. Ашиглалтын хугацаанд нийт 10,670.96 сая төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болно. 15 хувийн хорогдуулалтын норм тооцсон төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ 3,957.18 сая төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 46% байна. Хөрөнгө оруулалтаа ашиглалтын 1.3 жилийн хугацаанд нөхнө.

1.2.1. УУРХАЙН ХҮНИЙ НӨӨЦ, УУРХАЙН КЕМП

Уурхайд 1 ээлжинд 54 хүн ажиллах ба ээлжийн хуваариар тооцсоноор нийт 106 хүн ажиллана.

Хүснэгт № 8 Төслийн нийт ажилчдын тоо

№	Хэсэг нэгж	1 жилд
1	Уулын хэсэг	44
2	Угаан баяжуулах хэсэг	22
3	Засвар механикийн хэсэг	16
4	Аж ахуй, үйлчилгээний хэсэг	24
	Нийт	106

1.2.2. ДЭД БҮТЭЦ

Уурхайн захиргаа, засвар үйлчилгээний төв зэрэг барилга байгууламжууд нь MV-000296 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд нийт 1.5 га талбайг эзлэн байрлана.

Хүснэгт № 9 Барилга байгууламжийн мэдээлэл

№	Барилгын нэр	Хэмжих нэгж	Хэмжээ	Тайлбар
1	Уурхайн удирдлагын байр	м ²	56	Зөөврийн хаус
2	Ажилчдын сууц	ш	8	40 тн контейнер 6*29м ²
3	Цайны газар	м ²	40	Зөөврийн сууц
4	Хүнс ахуйн агуулах	ш	1	20 тн контейнер
5	Халуун ус болон угаалга	м ²	40	Зөөврийн сууц
6	Засварын газар, сэлбэгийн агуулах	м ²	160	20 тн контейнер 2 ш, мөн сэндвич
7	Засварын талбай	м ²	100	Шимт хөрсийг хуулж, талбайг тэгшилсэн байна
8	Түлшний ёмкост	тн	70	Шимт хөрсийг хуулж, талбайг тэгшилсэн байна

Цахилгаан хангамж: Уурхайгаас баруун хойд талд 10 км зайд байрлах ДСЦТС-110 кВ-ын шугамнаас салбарласан 35 кВ-ын Баянголын дэд станцаас 6 кВ-ын агаарын шугамын татан, 0.4 кВт-ын хүчдэлтэй 630 кВа-ын суурилагдсан хүчин чадалтай хаалттай дэд станц угсарч уурхайг цахилгаан эрчим хүч /ЦЭХ/-ээр хангаж байна.

Дулаан хангамж: Уурхайн барилга байгууламжууд, ажилчдын сууцыг сэрүүний улиралд цахилгаанаар халаана.

Усан хангамж: Олборлолт, ашиглалтын үйл ажиллагаатай холбогдон шаардлагатай унд-ахуйн болон үйлдвэрлэлийн ус хангамжийг тусгай зөвшөөрлийн талбайд өмнө нь гаргасан байсан унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалт бүхий гүний худаг, 2 ш үүсмэл нуурын уснаас хангахаар тооцлоо. Ордыг ашиглах үед усны дараах үндсэн хэрэглэгч байна. Үүнд:

- Унд ахуйн ус
- Технологийн ус
- Зам усалгаа
- Ногоон байгууламж усалгаа

Холбоо харилцаа: Уурхайн тосгонд Мобиком, Юнител зэрэг үүрэн телефоны сүлжээ барьдаг. Уурхайн экскаватор, автосамосвал зэрэг үндсэн тоног төхөөрөмжийн операторууд, ээлжийн дарга нар богино долгионы радио холбоогоор хангагдана.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Физик газарзүйн нөхцөл:

Төсөл хэрэгжих тусгай зөвшөөрлийн талбайнууд нь засаг захиргааны хуваариар Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн нутаг дэвсгэрт харьяалагддаг.

Төслийн талбай нь Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэг, Туул голын хөндийн зүүн талд Хайлааст нэртэй газар байрлана. Төслийн талбайн ойр орчмын алтны шороон ордууд нь Туул голын голдрил, татам, зүүн баруун дэнж, Заамарын нурууны амуудыг хамарч 900–1,815 метрийн үнэмлэхүй өндөртэй нутаг дэвсгэрт оршдог. Ордууд нь голын голдрил татам даган оршихоос гадна голын дэнжүүдийн нам гүвээ толгод хэлбэрийн өргөгдсөн гадаргууд болон Туул голын орчин үеийн хөндий рүү бараг хөндлөн маягаар чиглэж сунасан тогтоцтой амуудад байрлана. Ордуудын алт агуулсан давхарга нь гүвээ толгодын оройн хэсгийг хамарч, хярын шугамыг дагасан байрлалтай, мөн хуримтлалын нөлөөгөөр гуу жалга, жижиг голуудын голдрил дагуу оршино.

Цаг уур, уур амьсгал:

Төв аймаг нь Улаанбаатар хотыг хүрээлэх бөгөөд бусад талаараа Хэнтий, Говьсүмбэр, Дундговь, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ гэсэн зургаан аймагтай хиллэдэг. Хэнтийн уулархаг болон Хангай, Дорнод Монголын талархаг мужид багтах бөгөөд, дунджаар ДТД 1,200-1,500 м өндөрт оршино. Нийт 74,042.37 км² нутаг дэвсгэртэй үүнээс 16.4 хувийг ой мод, 36.5 хувийг хээрийн бүс эзэлнэ. Нутгийн хойд хэсгийн уулын өргөн хөндийнүүд нь газар тариаланд тохиромжтой хүрэн бор хөрстэй, өмнөд хэсэг нь гүвээ толгод бүхий тал хээр газартай байдаг.

Уур амьсгалын мужлалын хувьд чийглэгдүү, сэрүүн нэн хүйтэн; хуурайдуу, сэрүүвтэр хүйтэн, нэн хүйтэн бүсүүдэд оршдог.

Геологи, геоморфологи:

Геологи: Хайлаастын алтны үүсмэл шороон орд нь 360 x 80 м хэмжээтэй, уурхайн ухмалд дүүргэгчээр ашигласан, баруун урд болон зүүн урд талаараа үүсмэл нуураар, бусад хэсгээрээ угаагдсан элс хайргаар хязгаарлагдсан хар саарал, саарал өнгийн дөрөвдөгчийн хурдсаас тогтно. Харин доод хэсэгтээ занараар улладаг бол ордын дээд хэсэгт 0.4-1.2 м зузаантай угаасан элс, хайрганы үе тогтоогддог.

Хайлаастын алтны үүсмэл ордод өрөмдсөн цооногуудын зүсэлтээс үзэхэд дараах нийтлэг зүсэлт ажиглагдах бөгөөд XIII-0 Ц-0-т илрэх зүсэлтийг авч үзье. Үүнд:

1. 0.0-0.40 м Угаагдсан элс хайрганы үе 0.4 м
2. 0.4-10.0 м Хар хүрэн өнгийн ургамлын иш, үндэс бүхий хөрс болон саарал өнгийн хайрга, элс, шавранцар холилдсон үе
3. 10.0-12.0 м Ногоовтор саарал өнгийн сулавтар өгөршсөн занар

Геоморфологи:

Хайлаастын хөндий нь Туул голын баруун талын томоохон цутгалангийн нэг бөгөөд баруун хойш чиглэлтэй, 15 км орчим урт, 300-800 м өргөнтэй. Орчин үеийн сайр нь хуурай, зөвхөн зуны цагт хур тунадас ихтэй үед түр зуурын гадаргын ус урсдаг. Хайгуул, олборлолт гүйцэтгэсэн шороон ордын хүрээнд хөндийн хэлбэр зарим хэсэгтээ эрс өөрчлөгддөг бөгөөд эхэн хэсэгтээ 80-84-р шугамын орчимд 300-320 м өргөнтэй 11 хэлбэрийн хавцал маягийн хөндлөн зүсэлттэй. 80-р шугамаас доош огцом өргөсч 560 м хүрээд түүнээс доош адаг хүртлээ 450-850 м өргөнтэйгээр заримдаа тэвш хэлбэрийн, заримдаа II хэлбэрийн тэгш бус хэмт хөндлөн зүсэлттэй.

Хөндийн эхэнд доод палеозойн боржин, карбоны элсжин, хөрзөн чулуу бусад хэсэгт нь Заамар формац /E2-O1zm/-ын хувирмал чулуулгууд тархжээ.

Зүүн хойш, баруун хойш чиглэсэн хагарлын бүсүүдэд үүссэн энэ хөндийн хажуу, ёроолоор эвдрэл, бутралын, хүчтэй цахиуржилтын бүс хайгуулын малталт, геофизикийн мэдээллээр тогтоогдсон байна.

Харьцангуй богино зайд хөндийн хэлбэр, сэвсгэр хурдсын зузаан огцом өөрчлөгддөг нь хөндийн үүсэл удаан хугацаанд хэд хэдэн удаагийн тектоник хагарлын явцад бий болж блоклог тогтоцтой болсоныг харуулж байна. Дээрх хагарлуудын далайц шилжлийн өргөдөл суултаас хамаарч буй болсон элэгдлийн түвшингээр зарим геоморфологийн нэгж, түүнтэй холбоотой хурдас, алтны хуримтлал хадгалагдаж эсвэл зөөгддөг. Хөндийн хоёр хажуугаар 300-2500 м хүртэл урттай цухуйц /цокол/ дэнжийн 4 түвшингийн 4-5 м, 10-12 м, 16-20 м, 30 м буюу түүнээс их үлдэгдэл бий.

Дэнжийн эхний 3 түвшин аллюви-делювийн хурдсаар хучигддаг талбай ихтэй бөгөөд харин 4-р түвшингийн дэнж арал хэлбэртэй 20-300 м өргөнтэй дэнж гадаргад тодорхой илэрсэн байдаг.

Харин Хайлаастын үүсмэл шороон ордын улны гадаргын унал хайгуулын 0 шугамаас 4-р шугамын хооронд нэлээд тэгшивтэр, зүүн хойноосоо баруун ургааш 2-30 налуу гадаргуу үүсгэсэн Заамар формацын занар, элсэн чулуугаар улладаг.

Алтны үүсмэл шороон ордын ашигт давхарга нь баруун хойш сунаж тогтсон, тарпец маягийн хэлбэртэй. Уг давхарга нь энгийн тогтоцтой, 360 м урттай, 100 м өргөн, 6.40-11.60 м зузаантай, нэг давхарга юм. Уг давхаргад илэрсэн хамгийн бага агуулга нь 5.3 мг/м³, хамгийн их агуулга нь 212.1 мг/м³ хүртэл хэлбэлзэнэ.

Гадаргын ус:

Төслийн талбай нь ус зүйн хувьд дэлхийн ус хагалбарын Төв Азийн гадагш урсацгүй ай савд, Монгол орны Туул голын сав газарт багтана.

Заамар сум нь Монгол орны гадаргын усны сүлжээний томоохон төлөөлөл Туул голын сав газарт байрлах бөгөөд сумын нутаг дэвсгэрээр Туул, Тосон, Нарийн голууд урсана.

“Ирмүүн босго” ХХК-ийн MV-000296 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн баруун хойд зүгт ойролцоогоор 1.2 км-ийн зайд Туул гол урсаж байна.

Туул гол нь эхэндээ (эхээс 170 орчим км) олон тооны гол горхи, булаг ихтэй бөгөөд Хэнтийн нурууны салбар уулсаас эх авсан Галтгай, Хийд, Хаг, Зүүн баян, Тэрэлж, Улиастай, Сэлбэ зэрэг голууд цутгах ба харин голын уртын дагуугийн үлдэх ихэнхи доод хэсэгт Түргэн, Харбух, Тосон зэрэг цөөн тооны жижиг гол горхинууд цутгана. Голын ус хурах талбай 49,900 км, урт нь 874 км, ус хагалбарын шугамын урт 2,055.6 км, ус хурах талбайн дундаж өндөр 1,474 м, гулдрилын ерөнхий хэвгий 13% юм. Туул голын савд гол, горхины сүлжээний нягтшил дунджаар 0.39 км/км², хэсэглэн авч үзвэл голын эх Гачуурт хүртэл 0.54 км/км², Гачууртаас Лүн 0.1 км/км², Лүнгээс Заамарын алтны бүс Орхон Туулын бэлчир хүртэл 0.05 км/км² байна. Туул голын өргөн нь үергүй үед 35-75 м, гүн нь 0.8-3.5 м, урсгалын хурд 0.50-1.50 м/с, эргийн өндөр 0.5-2.5 м байдаг.

Гидрогеологи нөхцөл, газрын доорх усны нөөц, чанар, горим:

Судалгааны талбай нь гидрогеологийн ангилалаар Хангай-Хэнтийн гидрогеологийн мужид хамаарах бөгөөд тэжээгдлийн талбайн хэмжээ нь газрын доорхи усны хуримтлалын хэмжээнээс олон дахин илүү байдаг онцлогтой. Усны илүүдэл нь гадаргын усны урсгалыг голлон тэтгэх тул талбайн гадаргын ус нь харьцангуйгаар тогтмол горимтой байдаг. Судалгааны талбайд ус агуулагч хурдасны геологи-литологийн болон структурын онцлог, газрын доорхи усны гарал үүсэл, тэдгээрийн химийн найрлагыг харгалзан дараах уст давхарга бүрдлийг ялгаж болно.

а. Дөрөвдөгчийн настай хучаас хурдасны уст бүрдэл нь голын хурдасны, делюви-пролювийн хурдасны, нуур намгийн хурдасны уст давхаргууд гэж хуваагдана.

б. Мезо-кайнозойн сэвсгэр ба хатуурсан хурдасны уст бүрдэл

в. Ан цавын ус агуулагч бүрдэл

г. Гадаргуугийн ус

Хөрсөн бүрхэвч:

Төсөл хэрэгжих Төв аймгийн Заамар сумын нутагт нь хөрс-газарзүйн мужлалын Хангайн их мужийн Орхон-Туулын 14-р тойрогт багтана. (БНМАУ-ын Үндэсний Атлас, 1990).

Тус төслийн талбай нь Туул голын ай савын системд, Сэврэй уулын баруун хэсэг, Хайлаастын хөндийн дунд хэсэгт байрлах бөгөөд сүүлийн жилүүдэд эрчимтэй уул уурхайн ашиглалтын нөлөөгөөр ихээхэн доройтсон талбайд байршина.

Ирмүүн босго ХХК-ийн “Хайлаастын ордыг ашиглах” төслийн судалгаанд хамрагдсан MV-000296 тоот тусгай зөвшөөрөлтэй 228.21 га талбай, MV-020868 тоот тусгай зөвшөөрөлтэй 81.54 га талбайд уулын хар хүрэн хөрсний хэв шинж хөрс зонхилон тархсан боловч уул уурхайн олборлолтоос үүдэлтэй хүний үйл ажиллагаа болон аж ахуйн үйл ажиллагааны

нөлөөнөөс шалтгаалан хөрсөн бүрхэвч бүхэлдээ устан түүний оронд техноген гаралтай хөрс шорооны холимог битүү бүрхэж, тэдгээрт хөл газрын хог ургамал зонхилсон байна.

Ургамлан нөмрөг:

Энэ газар нутаг нь ургамал газарзүйн мужлалтаар хувьд Евразийн хээрийн их муж, Дагуур-Монголын уулын ойт хээрийн муж, Орхон Сэлэнгийн дэд мужид хамаарна Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Ирмүүн босго” ХХК-ийн бэлчээрийн ургамлан нөмрөгт судалгаа хийж, газрын төлөв байдал, ургамалжлын хэв шинжүүдийг тогтоох бичиглэл хийсэн. Газрын гадаргуу нь тэгширсэн газар, уулс хоорондын хотос, уулан дундах хотгор дахь бүтэц ул чулуулаг дээрх элэгдлийн суурьт тал толгодот, хөндийн ёроолоор, татмын нам дэнж үргэлжилнэ.

Судалгааны талбайн нь уулын ойт хээрт 17 овгийн 35 төрлийн нийт 45 зүйл ургамал бүртгэгдсэн. Энэхүү ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд

- ❖ сөөг 4 (9%)
- ❖ сөөгөнцөр 4, (9%)
- ❖ олон наст өвс 32, (71%)
- ❖ ганц ба хоёр наст 5 (11%) зүйл ургамал тус тус тэмдэглэгдэв.

Амьтны аймаг:

Монгол орны физик газарзүйн шинэ мужлалаар (Даш, 1999, 2015) Хангайн уулт их муж, Орхон-Туулын савын бэсрэг уулсын муж, Орхон-Ерөө голын савын дэд мужид хамаарна.

Төслийн талбайн орчим болон Туул голын сав газрын хэмжээнд 10 овгийн 16 зүйл загас, 2 зүйлийн хоёр нутагтан, 7 баг, 18 аймгийн 60 шахам зүйл хөхтөн, 171 зүйл шувуу бүртгэгдсэнээс 5 зүйл загас, 11 зүйл хөхтөн ховордож болзошгүй, 12 зүйл шувуу, нэг зүйл хөхтөн ховор, нэг зүйл шувуу, нэг зүйл хөхтөн нэн ховор ангилалд багтаж байна

Амьтны аймгийн зонхиологч бүлгэмдлийн хувьд хээрийн хөхтний бүлгэмдэл түүнээс тарвага, огодой, оготно зэрэг ургамлын ногоон хэсгээр амьдардаг экологийн онцлогтой, улирлын идэвхийн хувьд өвөлд ичээлдэг дээр дурьдсан зүйл амьтад зонхилно.

Тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын өв:

Төслийн талбайн орчинд улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг байхгүй болно. Хамгийн ойролцоо орших улсын ТХГН нь Хустайн нуруу БЦГ бөгөөд төслийн талбай хамгаалалтын бүсэд хамаарахгүй.

Төсөл хэрэгжүүлэгч нь 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Шинжлэх ухааны академи Палеонтологийн хүрээлэнтэй гэрээ байгуулан MV-000296, MV-020868 тоот тусгай зөвшөөрлүүд дээр судалгааны ажлыг хийж гүйцэтгүүлсэн байна. Палеонтологийн хайгуул, судалгааны ажлын дүгнэлтэд “Судалгааны талбайн ихэнх хэсэгт дөрөвдөгчийн эртний организмын үлдвэр агуулах боломжтой тунамал гаралтай чулуулаг тархсан байна. Талбайн маш бага хэсэгт дунд кембри-доод ордовкийн настай метаморф хурдас чулуулгийн гарш

илэрдэг. Палеонтологийн тандан судалгааг талбайд тархсан тунамал гаралтай чулуулагт гүйцэтгэсэн ба талбайн хэмжээнд эртний амьтан, ургамлын үлдвэр илрээгүй.

Гадаргын судалгаагаар макро түвшний эртний организмын үлдвэр илрээгүй ч Заамарын бүс нутагт гүйцэтгэсэн палеонтологийн сэдэвчилсэн судалгаагаар эртний хөхтөн амьтны чулуужсан үлдвэр олдож байсныг тэмдэглэсэн байдаг” гэжээ.

Мөн 2026 онд Монгол улсын их сургуулийн нүүдэлчдийн археологийн хүрээлэнгээр 2 тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд Археологийн авран хамгаалах судалгааг хийж гүйцэтгүүлсэн байна. Судалгааны ажлын дүгнэлтэд “Археологийн хайгуул судалгааны хүрээнд “Хайлааст” нэртэй талбайд археологийн дурсгал илэрч бүртгэгдээгүй бөгөөд цаашид тухайн талбайд үйл ажиллагаа явуулахад археологийн өвийг хадгалж хамгаалах хууль эрх зүйн үүднээс татгалзах зүйлгүй болно. Харин газрын хөрсөн дээр мэдэгдэх тэмдэггүй боловч хөрсөн доор булшлагдсан дурсгал байхыг үгүйсгэхгүй тул уул уурхайн ажлын явцад анхаарал болгоомжтой ажиллаж, ямар нэгэн дурсгал, олдвор илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад мэдэгдэхийг зөвлөж байна” гэжээ.

Нийгэм, эдийн засаг:

Төв аймгийн нийт хүн амын тоо 2025 оны байдлаар 92,537 байгаагаас хүйсийн байдлаар эрэгтэй 47,884 хүн, эмэгтэй 44,055 хүн байна. Заамар сумын нийт хүн амын тоо 5,575 байгаагаас эрэгтэй 2,880 хүн, эмэгтэй 2,618 хүн байна. Төсөл хэрэгжих 3-р баг Хайлаастанд 2,302 хүн байгаагаас эрэгтэй 1,191 хүн, эмэгтэй 1,068 хүн байна. Төв аймгийн өрхийн тоо 2025 оны байдлаар 28,751 байгаагаас төсөл хэрэгжих Заамар сумын өрх 1,708 байгаагаас Хайлааст багт 754 өрх байна.

Ажиллах хүчний судалгаанаас авч үзэхэд 2024 оны 1-р улирлын байдлаар Төв аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны хүн ам 63.9 мянга байгаагаас 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 38.4 мянга нь ажиллах хүч юм. Ажиллагчид 38.1 мянга, ажилгүй хүн 0.3 мянга байна.

Төв аймгийн дүнгээр ДНБ-ий үйлдвэрлэл 2023 онд 1.18 их наяд төгрөг болж 2016 оноос 1.4 дахин, 2017 оноос 1.5 дахин, 2018 оноос 1.2 дахин, 2019 оноос 88.1 хувиар, 2020 оноос 67.8 хувиар, 2021 оноос 38.7 хувиар, 2022 оноос 14.3 хувиар тус тус өслөө.

2024 оны Төв аймгийн ДНБ-ий 6.2 хувийг уул уурхайн олборлолт, 13 хувийг үйлдвэрлэл, 51.6 хувийг хөдөө аж ахуй, 29.2 хувийг үйлчилгээний салбар үйлдвэрлэж байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2024 оны байдлаар Төв аймагт 89,468 сая төгрөг байгаа нь өмнөх оныхоос 29,895.4 саяаар нэмэгдсэн байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл: Уурхайн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийн үр дагавар нь хөрсний талхлагдал, газрын хэвлийд үүсэх хоосон орон зай байна.

Төсөл хэрэгжих тусгай зөвшөөрлийн талбай MV-000296 нийт 228.21 га, MV-020868 нийт 81.54 га буюу нийтдээ 309.75 га газар байна. Одоогийн байдлаар MV-000296 талбайд ил уурхайгаар 77.69 га, барилга байгууламжаар 8.03 га, уурхайн шороон замын 3.95 га, нийт 89.67 га талбай үйл ажиллагаанд өртсөн, MV-020868 талбайд ил уурхайгаар 34.83 га, шимт хөрсний овоолгоор 0.43 га, уурхайн замаар 0.50 га үйл ажиллагаанд өртсөн байна.

Тэгвэл орд ашиглалтын ирэх 2 жилд үйл ажиллагааны явцад нийт 15.92 га, төслийн газрын гадарга, хэвлий нь техникийн болон хүний хүчин зүйлийн нөлөөлөлд нэмж өртөхөөр байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. Дээр дурьдсан сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахын тулд суурь байгууламжийн ажил дууссаны дараа орчныг тохижуулах нөхөн сэргээх, ургамалжуулах, далан хамгаалалтын зурвас байгуулах;
2. Хэрэгжих төслийн барилгын үе шат болон төсөл хэрэгжих явцад ашиглагдах машин техникүүдийн хөдөлгөөнийг зөвхөн зориулалтын тусгайлан зааж өгсөн маршрутаар зорчуулах, олон салаа зам гаргахгүй байх, MNS 4597:2014, MNS 4759:2014 стандартын дагуу тэмдэг, тэмдэглэгээ хийх;
3. Төсөл хэрэгжүүлэгч нь “Авто замын тухай хууль (шинэчилсэн найруулга) /2017.5.11/”-ийн 22-23 зүйлийг мөрдөн ажиллах шаардлагатай.
4. Газар зохион байгуулалт, газрын менежментийн төлөвлөгөөг Газрын төлөв байдал чанарын хянан баталгааны үед хийлгэж ашиглалтын дор өртөх газрын хэмжээг хамгийн бага хэмжээнд байлгах;
5. Газрын ашиглалт явуулахдаа эвдэрсэн газрыг эргэн нөхөн сэргээх боломжоор хангах үндсэн зарчмыг баримтлах. Үүний тулд газар ашиглалт явуулах дурын хэсэгт /засвар үйлчилгээ, хаягдал бохирдлын сан, тээврийн зам доор өртөх газрууд/ шимт хөрс болон ул хөрсний давхаргыг ялгавартай хуулж газар ашиглалтын дуусгавраар эргэн нөхөн сэргээлтэд ашиглах зарчмыг баримтлах шаардлагатай;

Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас уурхайн ухаш олборлолт, хүнд механизмуудын хөдөлгөөн, хөрсийг ачих, буулгах, тээвэрлэлтээс тоос, тоосонцор үүснэ.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. Хөрс хуулалт, тээвэрлэлтийн ажлыг аль болох салхи багатай өдөр хийж гүйцэтгэх,

2. Төслийн талбайн дотоод тээвэрлэлтийг аль болон олон салаа зам гаргахгүйгээр тээвэрлэх,
3. Зам талбайг хаврын улиралд тогтмол усалж байх шаардлагатай,
4. Орчны агаарт ялгаруулах хорт утаа хийг багасгахын тулд техникийн тогтмол засвар, үйлчилгээг хийж байх,
5. Уурхайн ажилчид, түүний орчимд ажиллаж байгаа ажилчдад дуу чимээний бохирдлоос хамгаалах хэрэгсэл буюу чихэвч зүүлгэх, ашиглах хэвшүүлэх арга хэмжээ авах,
6. Механик ажиллагаатай тоног төхөөрөмжид чичиргээний хамгаалалт суурилуулах, цагийг хязгаарлах,
7. Дуу чимээний эх үүсвэрийг мэдрэмтгий хүлээн авагчаас холдуулан байршуулах, хамгаалалт хийх, тоног төхөөрөмж, машин техникт байнгын үзлэг шалгалт хийх зэрэг болно.

Усан орчинд үзүүлэх нөлөөлөл: Газрын хөрсөнд ШТМ алдагдсанаар хөрсөнд нэвчин газрын доорх усыг бохирдуулах эрсдэл үүсэж болзошгүй, ахуйн шингэн хог хаягдал хөрс рүү нэвчин газрын доорх усыг бохирдуулах, усны нөөц хомстох зэрэг сөрөг нөлөөллүүд байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. Хур борооны усыг хуримтлуулан ашиглах
2. Үер болон борооны усаар зөөгдөн элдэв хог хаягдал хөрсөнд шингэхээс сэргийлж үерийн ус зайлуулах суваг, шуудууг байгуулах
3. Худгийг тоолууржуулан усны хэрэглээг хянах
4. Зориулалтын стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж бий болгон ашиглах, халдваргүйжүүлэлт хийх
5. Цэвэрлэх байгууламжид стандартад нийцсэн шүүлтүүр тавих, хаягдал усны шинжилгээ тогтмол хийлгэж үр дүнг хянаж байх
6. Аюултай хог хаягдлыг стандартын дагуу хадгалж, устгуулах
7. Авто зогсоолын хэсгийг хатуу хучилттай болгох

Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл: Хөрс хуулалт, овоолго хийх, дотоод тээвэрлэлтийн явцад ургамлан бүрхэвч устаж дарагдах, хог хаягдал, тоос тоосонцор салхиар дамжиж тархах болон хөрсөнд нэвчих байдлаар ургамал, хөрс, усыг бохирдуулах нөхцөл бүрдэнэ.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

1. Ашигласан талбайг ургамалжуулах ажлыг эхний ээлжинд зохиомол аргаар хийх бөгөөд цаашид байгалийн аясаар хөрс болон ургамлан бүрхэц тогтвортойгоор бүрдэх нөхцөлийг хангах,

2. Ургамалжуулалтын ажлыг зуны хур бороог угтуулан олон наст буурцагтан, үетэн зэргийг урьдаас бэлтгэсэн үрээр тарих
3. Тарилт хийхийн өмнө үрийн соёолох болон дасан зохицох чадвар, ус чийг, хуурайшилд хэр тэсвэртэй болохыг судалсан, биологийн үндсэн онцлогийг сайн мэдэх үрийг сонгох
4. Хучилтгүй зам дээр явах машины хурдыг хязгаарлах,
5. Зам, ажилчдын хотхон, бусад барилга байгууламжийн дэргэд ойн зурвас, чимэглэлийн ургамал таривал агаарын тоосжилтыг багасгах хүчилтөрөгчийн хангамжийг сайжруулахад чухал нөлөөтэй.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл:

Сөрөг нөлөөллүүд

Зэрлэг амьтдын амьдрах орчин өөрчлөгдөх, үхэж үрэгдэх, амьтдын хөлөөр элдэв халдварт өвчин тархах, мал амьтан гүн ухашруу унаж эрсдэх зэрэг сөрөг нөлөөллүүд байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. Хууль бус агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад онцгой анхаарч хяналт тавьж байх
2. Амьтны нүүдлийн замд хаалт саад тавихгүй байх
3. Төслийн талбай орчимд үзэгдсэн зэрлэг ан амьтдын бүртгэл хөтлөх
4. Төслийн талбай орчимд элдэв халдварт өвчин тараах тагтаа, хэрээ, жунгаа гэх мэт шувуудыг хэт олширохоос урьдчилан сэргийлж ил задгай хог хаягдал, хоол хүнсний үлдэгдэл хаяхгүй байх
5. Хамгаалалтын хашаа барих

Түүх соёлын дурсгалт зүйлст үзүүлэх нөлөөлөл: Түүх соёлын дурсгалт зүйлс нь ашиглалтанд өртөх талбайд илрээгүй байна.

Хэрэв ашигт малтмал ашиглалтын явцад хүн малын яс, шавар ваар савны хагархай, янз бүрийн хүрэл, төмөр эдлэл, түүний хэлтэрхий, хугархай гэх мэт хүний гараар хийсэн ямар нэг эд өлгийн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд орон нутгийн удирдлага, БО-ны хяналтын улсын байцаагч, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэж хамгаалалтанд авах ба дурдсан мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж малтлага судалгаа хийлгэхийг зөвлөж байна.

Төслөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилт, дуу чимээ, техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх магадлалтай.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. ХАБЭА тухай хууль, бусад холбогдолтой дүрэм журам, стандартын шаардлагуудыг мөрдөх, дотоодын хяналтын журам аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг нийт ажилтнуудад мөрдүүлэх, хяналт тавих шаардлагатай.

2. Техник, технологийн ба хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн горим журмыг зөрчихгүй байх, ажлын явцад хөдөлмөрийн сөрөг хүчин зүйлсийн хэмжээ ЗДХ-ээс хэтэрсэн тохиолдолд ажлаа шууд зогсоож удирдах ажилтнуудад яаралтай мэдэгдэх.

Төслөөс нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл: Улсад болон орон нутагт тодорхой хэмжээний татвар төлөх, ажлын байр хадгалагдах, орон нутгийн иргэдээс мах сүү, цагаан идээ зэрэг уламжлалт аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг худалдан авах зэрэг эерэг нөлөөлөл байна.

БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт: Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчны хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэгдсэн дараа дараачийн жилүүдэд хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай бөгөөд байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх үндэслэл: Олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоор Байгаль орчны менежмент гэдэг нь аливаа байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн явц, үр дүнг хянах удирдлагын үйл ажиллагаа бөгөөд энэ нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)–ний дагуу Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) –гоор хэрэгжих учиртай. БОМТ гэдэг нь тодорхой газар нутгийн байгаль орчныг хамгаалж холбогдох хууль журмыг сахих зорилгоор хийгдэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө юм. MNS (ISO) 2006 стандартад зааснаар БОУТ гэдэг нь байгууллагын удирдлагын тогтолцооны нэг хэсэг бөгөөд тухайн байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх болон байгаль орчинтой холбоотой асуудлыг хариуцах үүрэгтэй.

2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 31-р зүйлд зааснаар аливаа бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь БОМТ-ний хэрэгжилтийг хангах, өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд ялгаруулах хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах дотоод хяналтын нэгжтэй байх (заалт 31.7), байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төсөвтөө тусган хэрэгжүүлэх (заалт 31.4), БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх (заалт 31.10, 31.11) зэрэг үүрэгтэй (МУ хууль, БОХ тухай, 2012).

БОМТ-ний бүрдэл хэсэг, агуулга: Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБҮ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ

нь Байгаль хамгаалах төлөвлөгөө (БХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ (заалт 9.5). БХТ-нд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана (заалт 9.6). ОХШХ-т төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тодорхойлон тусгана (заалт 9.7).

Хуульд БОМТ-ний хэрэгжилтэнд байгаль хамгаалагч, БО-ны улсын байцаагч, Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, БО-ны ТББ хяналт тавина гэж заасан байна. Үүн дээр тухайн газар нутагт гарч байгаа өөрчлөлтийг хамгийн сайн мэдэх нутгийн малчид, ард иргэд болон шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээ, дүгнэлт өгөх мэргэжлийн байгууллагын хяналт зайлшгүй байх ёстой гэж үзэн нэмж оруулсан.

Өнөөгийн байдлаар БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар БОМТ-г боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу хийж гүйцэтгэж байна.

Байгаль хамгаалах төлөвлөгөө:

- ✓ Төслийн гол болон болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ
- ✓ Уул уурхайн төслийн хаалтын үед авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ, хамрах хүрээ;
- ✓ БОМТ-г хэрэгжүүлэх хүний нөөц, БО-ны удирдлагын бүтэц зохион байгуулалт;
- ✓ БОМТ-ний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийтэд тайлагнах төлөвлөгөө;

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр:

- ✓ Нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт;
- ✓ Нөлөөллийг багасгах, арилгах, нөхөн сэргээх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээний үр дүнг хэмжих тоон ба чанарын үзүүлэлтүүд;
- ✓ Төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол улсын хууль тогтоомж, стандарт болон хэм хэмжээний үзүүлэлтүүд;
- ✓ Хяналт-шинжилгээ хийх шаардлагатай байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүд, нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн;
- ✓ Сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, давтамж;

БОМТ-ний бүтэц: БОМТ-ний бүрэлдэхүүнд 5 бүлэг, 7 ерөнхий хэсэгтэй.

1. Оршил
2. Төслийн танилцуулга
3. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн товч танилцуулга
4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
5. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ
6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө
7. Дүгнэлт

БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнөөр үүсэх тоосжилт болон тээврийн хэрэгсэлийн яндангаас ялгарах хорт хий байна гэж үзсэн. Мөн техник, тээврийн хэрэгслийн үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээ байна. Тоосжилтыг бууруулахын тулд замын тоосыг усаар дарах болон барьцалдуулагч бодис ашиглан тоосыг тодорхой хугацаанд барих зэргийг зөвлөмж болгосон. Тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах хорт хийг бага байлгахын тулд техник, тээврийн хэрэгслүүдийн оношилгоо, тохиргоо, засвар үйлчилгээг тогтмол хийх шаардлагатай. Дуу чимээний бохирдлоос ажилчдыг хамгаалах дуу чимээ багасгах чихэвчээр хангахыг зөвлөж өгсөн.

Хүснэгт № 10 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	2026 он мян.төг	Давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7
1. АГААРЫН ЧАНАР							
1	Уурхайн дотоод тээврийн замаас үүсэх тоосжилт	Барьцалдуулагч ашиглах	Дотоод тээврийн зам	мян.төг	3,000.0	Тогтмол	-Агаарын тухай хууль, -Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. -MNS 3383:1982. Агаар мандал. Бохирдуулагчийн эх үүсвэрийг тодорхойлох
2. ГАДАРГЫН БА ГАЗРЫН ДООРХИ УСНЫ НӨӨЦ							
1	Усны нөөц хомсдох	Худгийг тоолууржуулах	Гүний худаг	мян.төг	500.0	2026 онд	-Усны тухай хууль, -Ус ашигласны төлбөр (2013 оны 327-р тогтоол) -Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
3	Газрын доорх ус бохирдох	Стандартын дагуу ариун цэврийн байгууламж нэмж барих	Газрын доорх ус	мян.төг	30,000.0	2026 онд	- MNS EN 12255–1:2012 Бохир ус цэвэрлэх байгууламж - MNS 4288:1995 Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил,

							цэвэрлэгээний технологи, түвшинл тавих үндсэн шаардлага
3. ХӨРСӨН БҮРХЭВЧ							
1		Замын тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Дотоод тээврийн зам	мян.төг	500.0		-Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, -MNS 3297:1991 Хөрс. Хот суурин газрын эрүүл ахуйн үзүүлэлтүүд -MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ -MNS 4601:2011 Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүн. Техникийн үйлчилгээ, засварын тогтолцоо
2	Тээвэрлэлтийн явцад олон салаа зам үүсэх	Орон нутгийн зам дагуу тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Орон нутгийн зам	мян.төг	300.0	Уурхайн ашиглалт эхлэхийн өмнө	
4. УРГАМЛАН НӨМРӨГ							
1	Ургамлан бүрхэвч үгүй болсноор тоосжилт, цөлжилт үүсэх	Ажилчдын хотхон болон бусад боломжит талбайд ногоон байгууламж бий болгох, арчлах	Ажилчдын хотхон	мян.төг	150.0	2026 онд	-Ургамал хамгааллын тухай хууль, -Байгалийн ургамлын тухай хууль, -MNS 5918:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага”
5. АМЬТНЫ АЙМАГ							
1	Мал, амьтан ил уурхайн ухаш, далан шуудууруу унаж эрсдэх	MV-000296 тоот тусгай зөвшөөрлийн талбайд байгаа нуурыг тойруулан хамгаалалтын хашаа барих, арчлах /607 м/	Уурхайн ухаш	мян.төг	9,105.0	2026 онд	"Амьтны аймгийн тухай" хууль: 6.1.7 дахь заалт: үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан хөнөөгдөхөөс сэргийлэх
Нийт				мян.төг	43,555.0		

5.1.2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн батлагдсан ТЭЗҮ-д тусгасны дагуу уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн ажлыг ашиглалтын 2 жил дууссаны дараа 3-4 дэх жилд хэрэгжүүлнэ. Иймд 2026 онд нөхөн сэргээлтийн ажил хийхгүй гэж үзэн энэхүү тайланд нөхөн сэргээтийн зардал тусгаагүй болно.

5.1.3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төв аймгийн Байгаль орчны газраас “Ирмүүн босго” ХХК-д Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-000296, MV-020868 тоот тусгай зөвшөөрөл бүхий “Хайлаастын алтны үүсмэл болон шороон ордуудыг ил аргаар ашиглах” төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд доорх ажлуудыг жил бүрийн төсвийн хүрээнд аймаг сумын удирдлагатай хамтран ажиллахаар төлөвлөлөө.

Хүснэгт № 11 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
	1	2	3	4	5
1	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	– Халзангийн даваа, Наймганы нуруу, түүний салбар уулсад амьтдын тоо толгойн хөдлөл зүйн мониторингийн судалгааг хийх – Ургамлан нөмрөг хамгаалах, бэлчээр сайжруулах судалгаа хийх	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	16,250.0	2026 он
	Нийт		16,250.0		

5.1.4. ТЭРБУМ МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ТАРИХ МОДНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд “Ирмүүн босго” ХХК нь жил бүр 10,000 ширхэг модыг Төв аймгийн Байгаль орчны газраас санал болгосон газарт тарихаар төлөвлөсөн бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн А/172,116 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын норматив”-ын дагуу навчит модны 1 га талбайн зардлын нормативаар зардлыг тооцлоо. Жил бүр тарих 10,000 ширхэг модыг 7 га талбайд тарина гэж тооцов.

Хүснэгт № 12 Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд тарих модны төлөвлөгөөний зардал

№	Хийгдэх ажил	Хэмжих нэгж	2026 он
1	Модны тоо	ш	10,000.0
2	Навчит модны 1 га талбайн зардлын норматив	мян.төг	6,600.0
3	Тарих талбайн хэмжээ	га	7
	Нийт	мян.төг	46,200.0

5.1.5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих тусгай зөвшөөрлийн MV-020868 тоот талбайд судалгаа хийх хугацаанд 2 айл нэг дор өвөлжөөндөө буусан байсан. Газрын гэрчилгээгүй бөгөөд төсөл хэрэгжих хугацаанд хаваржаа намаржаа болон зусландаа баруун урагш уулруугаа буюу төслийн талбайгаас гадагш нүүдэг байна.

Иймээс БОННУ-нд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгаагүй болно.

5.1.6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус ордын ойр орчинд археологи, палеонтологийн хайгуул судалгаагаар бүртгэгдсэн түүх соёлын дурсгалт газар байхгүй. Иймд түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөөгүй болно.

Цаашид “Ирмүүн босго” ХХК нь уурхайн ашиглалтын явцад хэрэв хүн малын яс, шавар ваар савны хагархай, янз бүрийн хүрэл, төмөр эдлэл, түүний хэлтэрхий, хугархай гэх мэт хүний гараар хийсэн ямар нэг эд өлгийн шинж тэмдэгтэй зүйлс илэрсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-т Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ; Ашигт малтмалын тухай хуулийн 40²-т заасны дагуу Соёлын өвийг хамгаалах талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг хүлээж ажиллах шаардлагатай.

5.1.7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөс шалтгаалж гэнэтийн осол гарахаас сэргийлж тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, үзлэг хийж засварлах, хянах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх шаардлагатай. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллаагүйн улмаас хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй гэнэтийн осол эрсдэлээс сэргийлж уурхайн ажил эхлэхийн өмнө тогтмол ажилчдын дунд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар сургалт зохион байгуулдаг байх, болзошгүй осол, хүний амь насанд аюул учруулж болох нөхцөлүүдээс урьдчилан сэргийлэх, ХАБЭА-н болон АУТөлөвлөгөөтэй байх шаардлагатай.

Хүснэгт № 13 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	2026 он мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7
1		Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгсэл, галын аюулын тухай самбар, тэмдэг, тэмдэглэгээг зохих газруудад байрлуулах	Уурхайн барилга байгууламж болон ил уурхай орчимд	500.0	Жил бүр	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17) -MNS6010-2009
2	Гэнэтийн гал түймрийн аюулын үед үүсэх эрсдэл	Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэргэжлийн байгууллагатай хамтран уурхайн ажилчдын дунд сургалт зохион байгуулах	Ажилчид	500.0	Жил бүр	Гамшгийн холбогдолтой нэр томьёо, тодорхойлолт, ерөнхий анги -MNS ILO OSH 1:2003, “ХААЭА-н удирдлагын тогтолцооны талаарх удирдамж”

						-Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль -MNS ISO 13688:2000, “ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага”
Нийт				1,000.0		

5.1.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

“Ирмүүн босго” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай.

Хүснэгт № 14 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	2026 он мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт ба аргачлал	
1	2	3	4	5	6	
1	Хатуу хог хаягдлын цэгийг шаардлагатай тохиолдолд засварлах, шинэчлэх	Хогийн цэг	200.0	Уурхайн ашиглалт эхлэхийн өмнө, цаашид шаардлагатай тохиолдолд	-Хог хаягдлын тухай хууль; -БОАЖ-ын сайдын А/433 тушаал “Ариун цэврийн тухай” хууль; -БОАЖ-ын сайдын 2017 оны А/349 тушаал - Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл; -БОАЖ-ын сайдын 2017 оны А/368 тушаал - Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлал; -БОАЖ-ын сайдын 2018 оны А/18 тушаал - Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах; -БОАЖ-ын сайдын 2018 оны А/443 тушаал - Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага; -БОАЖ-ын сайдын 2018 оны А/445 тушаал - Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар; -БОАЖ-ын сайдын 2018 оны А/21 тушаал,	
2	Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг шаардлагатай газруудад нэмж байршуулах	Уурхайн хотхон	300.0			
3	Аюултай хог хаягдлыг хадгалах хэсгийг тохижуулах, гэрээ байгуулан ачуулж зайлуулах	Хэрэглэсэн зай, ажилласан тос, ШТМ гэх мэт	1,000.0			
4	Ахуйн хог хаягдлаа орон нутагтай үргэлжлүүлэн гэрээ байгуулан тээвэрлүүлэх	Ахуйн хатуу хог хаягдал	1,000.0			Жил бүр
5	Бохирын цооногийг 70-90% дүүргэлттэй болох үед соруулан зайлуулж хэвших, шингэн хог хаягдал ачиж зайлуулах гэрээ байгуулах	Ахуйн шингэн хаягдал	1,000.0			Тогтмол

				MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага;
Нийт			3,500.0	

5.1.9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР


Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 12 сарын 27-ны өдрийн А/642 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орчны чанарын хяналт шинжилгээний ажил, үйлчилгээний хөлс, үнэ тариф”-ыг үндэслэн тооцов.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэрт Хайлаастын алтны үүсмэл болон шороон ордуудыг ил аргаар ашиглахаар “Ирмүүн босго” ХХК-аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа болон үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөлөх байдлын үнэлгээний нэг чухал баримт бичиг юм. ОХШХ нь БОХТ-тэйгөө нягт уялдсан байх бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө. Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Ирмүүн босго” ХХК нь батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 11 сард холбогдох сум, аймаг, төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Хүснэгт № 15 ОХШХ-ийн мониторингийн цэгүүдийн координат

№	Шинжилгээ авах төрөл	Мониторингийн цэг	
1	Агаарын сорьц шинжилгээ /PM2.5, PM10, TSP, дэгдэмхий органик нэгдэл, шуугианы түвшин тодорхойлох хэмжилт/ Уурхай, ажилчдын хотхон, уурхайн зам, баяжуулах хэсэг орчмоос	104° 30' 21.36"	48° 20' 43.15"
2		104° 31' 13.07"	48° 20' 28.56"
3		104° 32' 02.29"	48° 20' 03.46"
4		104° 32' 58.89"	48° 19' 46.41"
5	Хөрсний задлан шинжилгээ /агрохими, хүнд металл, эрүүл ахуй/ Уурхай, ажилчдын хотхон, уурхайн зам, засварын газар, ариун цэврийн байгууламж, баяжуулах хэсэг орчмоос	104° 30' 30.00"	48° 20' 26.00"
6		104° 31' 07.34"	48° 20' 27.68"
7		104° 32' 54.00"	48° 19' 43.00"
8		104° 32' 06.01"	48° 19' 17.91"
9		104° 32' 39.92"	48° 19' 28.15"
10		104° 32' 59.46"	48° 19' 51.90"
11		104° 30' 38.85"	48° 20' 04.22"
12	Нөхөн сэргээсэн газар болон хяналтын цэгийн ургамлын мониторинг судалгаа	104° 32' 06.01"	48° 19' 17.91"
13		104° 32' 39.92"	48° 19' 28.15"
14		104° 32' 59.46"	48° 19' 51.90"
15		104° 30' 38.85"	48° 20' 04.22"
16		104° 31' 23.70"	48° 20' 29.41"

17		104° 31' 14.63"	48° 20' 15.78"
18		104° 32' 26.88"	48° 19' 47.94"
19		104° 30' 31.66"	48° 20' 26.00"
20	Усны ерөнхий химийн шинжилгээ Гүний худгаас	104° 32' 00.45"	48° 19' 53.34"
21	Хаягдал усны шинжилгээ	104° 31' 44.40"	48° 20' 03.14"
22	Тунах нуураас	104° 32' 56.55"	48° 19' 33.60"



Зураг № 4 ОХШХ-ийн мониторингийн цэгүүд

Хүснэгт № 16 Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж, жил	2026 он мян.төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7
1. Агаарын чанар						
1	(PM10, PM2.5, SO ₂ , NO ₂ , CO)	Ил уурхай, зам, баяжуулах хэсэг	4	2	400.0	- MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - MNS 6063:2010 Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулагч бодисын хүлцэх хэмжээ
2	Дуу шуугиан	Ил уурхай, зам, ажилчдын хотхон	4	2	120.0	
3	Дэгдэмхий органик нэгдэл	Ил уурхай, зам, баяжуулах хэсэг	4	2	80.0	
2. Хөрсний чанар						
1	Агрохими	Ил уурхай орчимд, ажилчдын хотхон, зам, баяжуулах хэсэг	5	2	350.0	- -MNS 3985: 1987. Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл - -MNS 3310:1991. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох
2	Хүнд металл	Ил уурхай, Засварын газар	2	2	300.0	
3	Эрүүл ахуй	Ариун цэврийн байгууламж	1	2	150.0	
3. Усны чанар						
1	Усны ерөнхий үзүүлэлтүүд, микробиологийн шижилгээ	Гүний худаг	1	2	80.0	- MNS 0900:2018. Ундны ус, ундны усны хяналт шинжилгээ - MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх - MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага.
2	Хаягдал усны шинжилгээ	Тунаах нуур	2	1	90.0	
4. Ургамлан нөмрөг						
1	Ургамлын мониторинг судалгаа хийх	Мониторингийн цэгүүдэд	8	1	2,000.0	
Нийт					3,570.0	

5.1.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журамыг байгаль орчны мэргэжилтэн тогтоож мөрдөх, Байгаль хамгаалахад ОН-н иргэдийн оролцоог идэвхижүүлэх уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах, БО-г хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах шаардлагатай.

Хүснэгт № 17 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	2026 он мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6

1	Ажилчдад ХАБЭА-н талаар сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	ХАБЭА удирдлага	500.0	Жил бүр	- -MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй - Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 5
2	MV-020868 тусгай зөвшөөрлийн талбайд Газрын чанарын хянан баталгааг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх	Уурхайн удирдлага	3,000.0	5 жил тутам	
Нийт			3,500.0		

5.1.11. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт № 18 БОМТ-ний хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7
1	БИНХ буюу нөлөөллийн бүсийн айлуудад	Уулзалт, санал асуулга, танилцуулга хэлбэрээр	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах	11-р сар	Тайлагнах	Хайлааст БИНХ
2	БОУАӨЯ	Тайлангийн эх хувь, албан бичиг	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	Тайлагнах	БОУАӨЯ
3	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Танилцуулж тайлагнах	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Хагас жил тутам буюу 6, 11 сард	Цаашид анхаарах асуудал	ЗДТГ, БОГ

5.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ

Хүснэгт № 19 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	х.нэгж	2026 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	мян.төг	43,555.0
2	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	мян.төг	16,250.0
3	Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд тарих модны төлөвлөгөө	мян.төг	46,200.0
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	мян.төг	1,000.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	мян.төг	3,500.0
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	мян.төг	3,570.0
7	Тухайн жилийн удирдлага зохион байгуулалт	мян.төг	3,500.0
Нийт		мян.төг	117,575.0

Хайлаастын алтны үүсмэл болон шороон ордуудыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд 2026 онд нийт 117,575.0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

ДҮГНЭЛТ

Төв аймгийн Заамар сумын нутагт орших Хайлаастын алтны үүсмэл болон шороон ордуудыг ил аргаар ашиглах төсөлд Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль” зэрэг хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжуудад тулгуурлан байгаль орчны тухайн жилийн менежментийн төлөвлөгөөг хийлээ.

“Ирмүүн босго” ХХК-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад дараах дүгнэлтэнд хүрлээ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн, уулын ажлыг батлагдсан зураг төсөл, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн нөхцөлд сөрөг нөлөөллүүдийг бууруулах боломжтой. Төсөл хэрэгжих явцад агаар, хөрс, ус, амьтан, ургамал зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд тодорхой хэмжээний сөрөг нөлөөлөл үзүүлэх бөгөөд тус сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахын тулд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөж ажиллавал зохино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд 2026 онд 117,575.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөлөө. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.10 -т зааснаар төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг зохистой ашиглах, Монгол улсын холбогдох хууль тогтоомжууд болон олон улсад нийтээр хүлээн зөвшөөрсөн байгаль орчны стандартуудыг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих, байгаль орчинд халгүй үйл ажиллагаа явуулах үр ашгийг тогтмол дээшлүүлэх, шинэ дэвшилтэт технологийг хөгжүүлэн нэвтрүүлэхэд зарцуулах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгож, нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 %-ийг БОУАӨЯ-ны төсөвт байршуулах шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг цаг тухайд бүрт мөрдлөг болгож, хэрэгжүүлсэн нөхцөлд энэхүү төслийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бүрэн боломжтойгоос гадна шинээр ажлын байр нэмэгдэх, орон нутагт их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэх төлөвлөгөөтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Төв аймгийн Заамар сумын нутагт орших Хайлаастын алтны үүсмэл болон шороон ордуудыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1, УБ, 2025 он
2. Төв аймгийн Заамар сумын нутагт орших Хайлаастын алтны үүсмэл болон шороон ордуудыг ил аргаар ашиглах төслийн “Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан” УБ, 2026 он
3. Төв аймгийн Заамар сумын нутагт орших Хайлаастын алтны үүсмэл болон шороон ордуудыг ил аргаар ашиглах төслийн “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан” УБ, 2026 он
4. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он
6. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
7. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” Сайдын А/618 тоот тушаал, 2019 он
8. “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам” Засгийн газрын 58-р тогтоол, 2023 он
9. Байгаль орчны сайдын тушаал: 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаал, Байгаль орчны үнэлгээний аргачилсан заавар.
10. <http://www.legalinfo.mn>